



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 14

Арвайхээр

Салбар комисс байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.4.2, 5, 6 дугаар дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын аймгийн Салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Энхцэцэг (Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Нарийн бичгийн дарга: Э.Бадамгэрэл (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд: Л.Ламаачин: (Аймгийн Ерөнхий аудитор, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Т.Гончигдорж (Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

А.Отгонцэцэг (Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

С.Дуламсүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

В.Шоовдор (Арвайхээр сумын ЗДТГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг цахимаар хийж, шалгалт авах байр, компьютер, интернэтийн сүлжээ, эрчим хүчний найдвартай байдлыг бий болгож, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг Салбар комиссын бүрэлдэхүүн /Н.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын дүнг 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүнг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар комиссын нарийн бичгийн дарга /Э.Бадамгэрэл/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНБОЛД

03 0027